



НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2024 оны 10 сарын 31 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Гамшгийн эрсдэлийг бууруулах
орон нутгийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах
журмыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2, 22.5 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэг, 27 дугаар зүйл, 31 дүгээр зүйл, 51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсгийг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус II хурлаас ТОГТООХ нь:

1. Гамшгийн эрдслийг бууруулах орон нутгийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Гамшгийн эрдслийг бууруулах орон нутгийн зөвлөлийн ажиллах журмын хэрэгжилтийг хангуулан, зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж, гамшгийн эрсдэлийг бууруулах санг, жил бүр бүрдүүлж ажиллахыг дүүргийн Засаг дарга Б.Цэрэн, Онцгой байдлын хэлтсийн дарга, хурандаа Д.Бат-Эрдэнэ нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Гамшгийн эрдслийг бууруулах орон нутгийн зөвлөлийн дарга (Ч.Бат-Оргил)-д даалгасугай.

4. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 02 сарын 14-ний өдрийн 04 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ч.БАТ-ОРГИЛ

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ОРОН НУТГИЙН
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

1.Дарга	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга
2.Гишүүн	Дүүргийн Засаг дарга
3. Гишүүн	Дүүргийн Засаг даргын орлогч
4. Гишүүн	Дүүргийн Газар зохион байгуулалтын албаны дарга
5. Гишүүн	Н.Туяанцэцэг /Төлөөлөгч/
6. Гишүүн	Ц.Оюунгэрэл /Төлөөлөгч/
7. Гишүүн	С.Жамсран /Төлөөлөгч/
8. Гишүүн	И.Сарангэрэл /Төлөөлөгч/
9. Гишүүн	Ц.Чинзоригт /Төлөөлөгч/
10. Гишүүн	О.Ганхуяг /Төлөөлөгч/
11. Гишүүн	Д.Мөнхбаяр /Төлөөлөгч/
12. Гишүүн	Ц.Эрдэнэцэцэг/Төлөөлөгч/
13. Гишүүн	Д.Алимаа /Төлөөлөгч/
14. Гишүүн	Б.Наранцацралт /Төлөөлөгч/
15. Гишүүн	Б.Алтантуяа /Төлөөлөгч/
16. Гишүүн	Я.Энхбаатар /Төлөөлөгч/
17. Гишүүн	Б.Ариунболд /Төлөөлөгч/
18. Гишүүн	А.Отгон-Эрдэнэ /Төлөөлөгч/
19. Гишүүн	Ц.Алтангэрэл /Төлөөлөгч/

20. Орлогч дарга

Нарийн бичгийн дарга

Онцгой байдлын хэлтсийн дарга

Ажлын албаны дарга

Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны .10..дугаар сарын .31.-ны өдрийн
..08..дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ОРОН НУТГИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн болон салбар дундын хамтын ажиллагаа, иргэдийн оролцоог хангах, бодлогын зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл (цаашид “орон нутгийн зөвлөл” гэх)-ийн үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Орон нутгийн зөвлөл нь Гамшгаас хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг, “Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн ажиллах журам”-ыг удирдлага болгож үйл ажиллагаагаа явуулна.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

2.1.Орон нутгийн зөвлөлийг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга тэргүүлж, Онцгой байдлын хэлтсийн дарга, орлогч дарга нар удирдлага зохион байгуулалтаар хангана.

2.2.Орон нутгийн зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажпын албаны дарга, Онцгой байдлын хэлтсийн гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн гүйцэтгэнэ.

2.3.Дүүргийн газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөл нь орон нутгийн зөвлөлийн дэд зөвлөл байна.

2.4.Дүүргийн онцгой комисс, гамшгаас хамгаалах албад нь чиг үүргийн хүрээнд орон нутгийн зөвлөлтэй үйл ажиллагаагаа уялдуулж ажиллана.

Гурав. Орон нутгийн зөвлөлийн бүрэн эрх

3.1.Орон нутгийн зөвлөл нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан бүрэн эрхээс өөрийн эрх хэмжээнд хамаарах эрхийг хэрэгжүүлнэ.

3.2.Орон нутгийн зөвлөлийн гишүүн дараах эрхтэй байна:

3.2.1.Шаардлагатай тохиолдолд орон нутгийн зөвлөлийн ээлжит бус хуралдааныг хуралдуулах саналыг орон нутгийн зөвлөлийн даргад танилцуулах;

- 3.2.2.Гамшгийн эрсдлийг бууруулах үйл ажиллагаа, орон нутгийн зөвлөлөөс гарсан зөвлөмжийн хэрэгжилтэд шаардагдах судалгаа, мэдээ, мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах;
- 3.2.3.Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр эрхэлсэн салбарт хэрэгжүүлэх арга хэмжээ, салбар хоорондын зохицуулалтыг хангах асуудлыг орон нутгийн зөвлөлийн хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах Нийслэлийн зөвлөлийн хуралдаанд санал хүргүүлэх;
- 3.2.4.Орон нутагт гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр бодлогын зөвлөмж гаргах, нутгийн захиргааны байгууллагад чиглэл өгөх;
- 3.3.Орон нутгийн зөвлөлийн гишүүн дараах үүрэгтэй байна:
- 3.3.1.Гамшгийн эрсдэлийг бууруулах эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг хангах, хэрэгжүүлсэн ажлаа орон нутгийн зөвлөлийн хуралдаан, холбогдох байгууллага, албан тушаалтанд тайлагнах, шаардлагатай тохиолдолд ажлын албанд хүргүүлэх;
- 3.3.2.Гамшгийн эрсдэлийг бууруулахтай холбоотой бодлогын зөвлөмж боловсруулах, бусад гишүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж салбар дундын зохицуулалтыг хангах;
- 3.3.3.Орон нутгийн зөвлөлөөс гарсан шийдвэр, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх;
- 3.3.4.Үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлыг тухайн жилийн төсөвт тусгах санал боловсруулах;
- 3.4.Орон нутгийн зөвлөлийн гишүүдийн гарт олгох урамшууллыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй адилтган тогтооно.

Дөрөв. Орон нутгийн зөвлөлийн хуралдаан

- 4.1.Орон нутгийн зөвлөлийн ажиллах үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Хуралдааныг орон нутгийн зөвлөлийн дарга зарлан хуралдуулна.
- 4.2.Орон нутгийн зөвлөлийн хуралдааны шийдвэр нь зөвлөмж байна.
- 4.3.Орон нутгийн зөвлөлийн ээлжит хуралдааныг жилд 2-оос доошгүй удаа хуралдуулна. Шаардлагатай тохиолдолд ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулж болно.
- 4.4.Ээлжит хуралдааны товыг хуралдаан болохоос 5-аас доошгүй хоногийн өмнө гишүүдэд мэдэгдэж, хурлын материалыг хүргүүлсэн байна.
- 4.5.Орон нутгийн зөвлөлийн хуралдааныг нийт гишүүдийн олонх буюу 50 хувиас дээш ирцтэй оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцно. Хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг гишүүдийн олонхын саналаар, санал тэнцсэн тохиолдолд хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.
- 4.6.Орон нутгийн зөвлөлийн даргын шийдвэрээр хуралдаанд холбогдох эрдэмтэн, судлаач, мэргэжилтэн, олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, иргэдийн төлөөлөл оролцуулж болно.

Тав. Орон нутгийн зөвлөлийн нарийн бичгийн даргын үйл ажиллагаа

- 5.1.Орон нутгийн зөвлөлийн нарийн бичгийн дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
 - 5.1.1.Хуралдааны бэлтгэлийг хангах, хуралдааныг зохион байгуулах;
 - 5.1.2.Орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад гишүүдээс гадна бусад холбогдох талуудыг татан оролцуулах, хяналт тавих;
 - 5.1.3.Орон нутгийн зөвлөлд ирүүлсэн санал, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлүүлэх;
 - 5.1.4.Хуралдааны шийдвэрийг холбогдох байгууллагад хүргүүлэх, биелэлтийг гаргуулах;
 - 5.1.5.Орон нутгийн зөвлөлөөс зохион байгуулж байгаа ажил, түүний явц, үр дүнгийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх, сурталчлах;
 - 5.1.6.Орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагаанд шаардлагатай баримт бичиг, мэдээ, мэдээлэл, судалгааг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдээс гаргуулан авах;
 - 5.1.7.Эрх, үүргээ хэрэгжүүлээгүй орон нутгийн зөвлөлийн гишүүд, холбогдох талуудад хариуцлага хүлээлгэх саналыг орон нутгийн зөвлөлийн даргад танилцуулах;
 - 5.1.8.Орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнах, жилийн үйл ажиллагааны тайланг нийслэлийн зөвлөлд хүргүүлэх;
 - 5.1.9.Орон нутгийн зөвлөлийн нарийн бичгийн дарга Ажлын албаны үйл ажиллагааны хэрэгжилтийг хангахад хамтран ажиллах;

Зургаа. Бусад

- 6.1.Орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсөвт тусган санхүүжүүлнэ;
- 6.2.Зөвлөл нь холбогдох журмын дагуу албан бичиг хэвлэмэл хуудас хэрэглэнэ;
- 6.3.Орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан арга хэмжээний зардлыг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсэгт заасны дагуу бүрдүүлж, тухайн жилийн төсөв болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ;